



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өндөр-Улаан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: АРА-2021/4/СТА-ТТЗ

<p>Хаяг: Архангай аймаг, Эрдэнэбулган сум. Аймгийн ЗДТГ-ын байр “А” корпус, 3 давхар зүүн жигүүр.</p> <p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Д.Уламбаяр Утас: 70333141 Цахим хаяг: UlambayrD@audit.gov.mn Аудитын менежер: Т.Байгалмаа Утас: 70332860 Цахим хаяг: BaigalmaaT@audit.gov.mn Аудитор: J.Mungunshagai Утас: Цахим хаяг: MungunshagaiJ@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Аудитын код: АРА-2021/4/СТА-ТТЗ.....	0
1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.2 Авлага.....	12
3.5.3 Бараа материал	12
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	13
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	14
3.5.10 Орлогын данс	14
3.5.11 Зардлын данс.....	15
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	15
3.7 Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	18
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	19
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	20
Дараагийн аудитад шилэн дансны мэдээлэл, сум хөгжүүлэх сангийн талаар шалгах зүйтэй гэж үзлээ.....	20
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	22
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХСан	Орон нутгийн хөгжлийн сан
СХСан	Сум хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

1. Аудитын гэрчилгээ

 АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРНИЙ АУДИТЫН ГАЗАР 65130 Цэцэрлэг, Архангай аймаг Утас/Факс: 976-70333141 И-мэйл: arkhangai@audit.gov.mn	ӨНДӨР-УЛААН СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ Ю.БААСАНЖАРГАЛ ТАНАА
<u>2021.03.25</u> № <u>130</u> танай _____ -ны № _____ -т	
АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	
Зөрчилгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Өндөр-Улаан сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Өндөр-Улаан сумын ТЭЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
Бусад мэдээлэл	
<p>Сумын засаг дарга бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын засаг даргын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 21 зорилын хүрээнд 100 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 75 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.</p> <p>Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.</p>	
Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын 2015 оны 341-р тушаалаар баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p> <p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.</p>	

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red rectangular official stamp is placed over a handwritten signature. The stamp contains Mongolian text, including the name 'Д.УЛАМБАЯР' and the title 'ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР'. The signature is written in black ink and is partially obscured by the stamp.

Д.УЛАМБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	665,795.1	832,913.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	75,918.8	215,810.1
33	АВЛАГА	400,532.5	410,838.0
35	БАРАА МАТЕРИАЛ	189,343.8	206,265.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,312,817.1	6,226,923.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,312,817.1	6,226,923.4
39200	Биет хөрөнгө	6,148,586.7	6,060,864.3
39300	Биет бус хөрөнгө	164,230.4	166,059.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,978,612.3	7,059,837.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	414.8	1.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	414.8	1.0
41300	Өглөг	414.8	1.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,978,197.5	7,059,837.0
51	Засгийн газрын хувь оролцоо	6,978,197.5	7,059,837.0
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,839,967.8	2,839,967.8
51200	Хуримтлагдсан үр дүн	2,274,146.6	2,355,786.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,864,083.2	1,864,083.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,978,612.3	7,059,837.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,923,506.3	3,766,159.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	159,539.5	251,032.8
110	Орлогын албан татвар	83,632.1	154,477.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	83,632.1	154,328.2

1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч		149.0
113	Хөрөнгийн албан татвар	2,910.0	2,910.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	72,997.4	93,645.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,690,093.9	426,277.3
120	Нийтлэг татварын бус орлого	1,690,093.9	426,277.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,073,872.9	3,088,849.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,395,735.6	3,516,756.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,395,735.6	3,516,756.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,915,082.4	3,427,913.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,844,349.9	2,131,046.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,807.0	285,097.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,287.6	126,015.0
2104	Хангамж, бараа материалын зардал	89,186.4	133,710.7
2105	Нормативт зардал	178,051.0	162,981.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,919.3	18,688.2
2107	Томилолт, зочны зардал	10,155.4	7,444.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,267.6	77,632.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	405,058.2	485,297.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	480,653.2	88,843.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,527,770.7	249,402.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	143,588.6	167,763.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,384,182.0	81,639.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,441,274.7	3,568,037.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	159,539.5	251,032.8
110	Орлогын албан татвар	83,632.1	154,477.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	83,632.1	154,328.2
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч		149.0
113	Хөрөнгийн албан татвар	2,910.0	2,910.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	72,997.4	93,645.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	14,494.0	14,950.2
1181	Газрын төлбөр	20,493.1	43,735.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	38,010.3	34,959.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	207,862.4	228,155.2
120	Нийтлэг татварын бус орлого	207,862.4	228,155.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,073,872.9	3,088,849.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,047,853.7	3,024,972.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,047,853.7	3,024,972.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,568,097.5	2,936,367.5

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,844,330.6	2,144,779.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	230,616.8	284,945.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107,584.2	127,576.7
2104	Хангамж, бараа материалын зардал	82,010.4	96,829.9
2105	Нормативт зардал	179,799.4	121,080.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,764.2	21,551.4
2107	Томилолт, зочны зардал	10,155.4	7,444.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,994.9	69,158.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,841.6	63,001.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	479,756.2	88,605.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	393,421.0	543,064.5
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	183,649.8	175,923.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	183,649.8	175,923.3
2200	Дотоод эх үүсвэрээр	183,649.8	175,923.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-183,649.8	-175,923.3
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-199,000.0	-227,250.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	199,000.0	227,250.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	10,771.2	139,891.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	65,147.6	75,918.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	75,918.8	215,810.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,978,197.5	6,978,197.5
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,978,197.5	6,978,197.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,978,197.5	6,978,197.5
19	Тайлант үеийн үр дүн	81,639.4	81,639.4
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,059,837.0	7,059,837.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,462,614.30	3,361,821.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,020,511.80	2,969,498.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,965,623.20	2,920,471.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,156,708.50	2,144,779.78
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	296,169.20	284,945.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,579.70	127,576.70
2104	Хангамж, бараа материалын зардал	93,470.30	92,839.30
2105	Нормативт зардал	139,493.10	118,907.65
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,501.40	22,501.40
2107	Томилолт, зочны зардал	7,644.00	7,444.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,019.60	65,760.17
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,037.40	55,716.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,888.60	49,026.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	214,852.50	165,073.97
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	227,250.00	227,250.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,462,614.30	3,400,811.94
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,251,756.80	2,203,002.94
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,251,756.80	2,203,002.94
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	882,802.30	910,638.00
320001	Орон нутгийн төсвөөс	675,654.60	703,490.30
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	207,147.70	207,147.70
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	61,500.00	60,320.98
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	61,500.00	60,320.98
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	266,555.20	226,850.02
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	202,400.00	226,850.02
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	64,155.20	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		47,468.45
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		86,458.39

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,573.00	1,605.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	7.00	7.00
610001	Төсвийн байгууллага	7.00	7.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	0.00	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	197.00	198.00
620001	Удирдах ажилтан	9.00	9.00
620002	Гүйцэтгэх ажилтан	116.00	110.00
620003	Үйлчлэх ажилтан	53.00	69.00
620004	Гэрээт ажилтан	19.00	10.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,172.00	1,202.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	781.00	811.00
630001	Төрийн өмчит ЕБС	781.00	811.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	391.00	391.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	391.00	391.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	197.00	198.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	16.00	14.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	75.00	71.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	4.00	4.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	23.00	23.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	63.00	79.00
650010	Гэрээт ажилтан	13.00	4.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	3.00	3.00

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,745.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,745.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,745.62
2104	Хангамж, бараа материалын зардал	4,481.36
2105	Нормативт зардал	2,172.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,506.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,585.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	26,745.62
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	26,745.62
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,834.60
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,911.02

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Өндөр-Улаан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Ю.Баасанжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасах болно.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 15-аас 2021 оны 3 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 3 дугаар сарын 24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Мөнгөншагай гүйцэтгэв.

Өндөр-Улаан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 5-ний өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Өндөр-Улаан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны зорилго нь Нутгийнхаа байгаль орчинг хамгаалан, хүний ба бизнесийн хөгжлийн таатай орчинг бүрдүүлэн, үйлдвэрлэл үйлчилгээний салбарыг жигд хөгжүүлсэн, нийгэм эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлэх сум болох” зорилго тавьж дараах гол зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- ✓ Эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгож, хэрэглэгч сумаас үйлдвэрлэгч сум болох суурь нөхцөлийг бүрдүүлэх
- ✓ Ажлын байрыг 2-3 дахин нэмэгдүүлж, ажиллах хүчний байршлыг хүн амын суурьшил, газар нутгийн зохион байгуулалт, эдийн засгийн бүтэцтэй уялдуулан зөв байршуулах
- ✓ Нийгмийн дэд бүтэц, орон сууцны хангамжийн хувийг дээшлүүлэх

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Өндөр-Улаан сумын Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Сангийн сайдын 2015 оны 341-р тушаалаар баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Өндөр-Улаан сумын удирдлагын байгууллагууд нь санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, НББ-ийн тухай хууль тогтоомж зөрчигдөх, санхүүгийн тайланг бэлтгэхэд баримтлах зарчим алдагдах зэрэг үр дагавартай байна.

Өндөр-Улаан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна. Төсвийн шууд

захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.

Өндөр-Улаан сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад аудитаар илэрсэн алдаа зөрчлийг эс тооцвол дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,167,140.1 мянган төгрөгийн 1 хувь буюу 41,671.4 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 75,918.8 мянга, эцсийн үлдэгдэл 215,810.0 мянган төгрөг болж 139,891.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бүүрэлт (-)</u>
<u>Төрийн сангийн харилца</u>	<u>75,918.8</u>	<u>215,810.0</u>	<u>139,891.2</u>
Үүнээс байгууллагын төрлөөр			
Орон нутгийн ерөнхий орлого	28,450.4	129,351.7	100,901.3
Орон нутгийн хөгжлийн сан	5,704.8	49,778.5	44,073.7
Сум хөгжүүлэх сан	41,763.6	36,679.8	(5,083.8)
Дүн	75,918.8	215,810.0	139,891.2

Эх сурвалж: Өндөр-Улаан сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 139,891.2 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн 21,872.8 мянган төгрөгийн 4 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүйгээс санхүүжилт олгогдоогүй, мөн сум хөгжүүлэх сан 36,679.8 мянган төгрөг, орон нутгийн ерөнхий орлогын данс 129,351.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

3.5.2 Авлага

Авлагын данны үлдэгдэл 410,838.0 мянган төгрөг бөгөөд өмнөх оноос 9,905.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Сум хөгжүүлэх сан	400,351.3	410,438.0	10,086.7
Хүүхдийн цэцэрлэг	106.6	0.0	-106.6
Ахлах сургууль	74.5	0.0	-74.5
Сумын Засаг даргын тамгын газар	0.0	400.0	400.0
Дүн	400,532.4	410,438.0	9,905.6

Эх сурвалж: Өндөр-Улаан сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хүснэгтээс харахад Хүүхдийн цэцэрлэг, Ахлах сургуулийн 181.1 мянган төгрөгийн авлага буурсан хэдий ч ЗДТГазрын авлага 400.0 мянган төгрөгөөр өссөн, сум хөгжүүлэх сангийн авлага 10,086.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Сум хөгжүүлэх сангийн 410,438.0 мянган төгрөгийн авлагыг зээлийн ангиллаар авч үзвэл 366,106.2 мянган төгрөг буюу 89.2 хувь нь хугацаандаа төлөгдөж байгаа хэвийн зээл, 41,791.4 мянган төгрөг буюу 10.1 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 2,540.3 мянган төгрөг буюу 0.6 хувь нь чанаргүй зээл байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийг төлүүлэхээр хугацаатай мэдэгдэл хүргүүлж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Тайлант онд сумын ЗДТГазар нь албан хаагчид 400.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгосон боловч суутгаагүй, авлагаар тусгаагүй байсанд санхүүгийн тайланд авлагаар тусгуулан залруулга хийлгэсэн байна.
- Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл болох нийт 44,331.7 мянган төгрөгөнд зөвлөмж хүргүүлээ.

3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 189,343.8 мянга, эцсийн үлдэгдэл 206,265.4 мянган төгрөг болж, 16,921.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1,397.5	9,165.9	7,768.4
Эм боох материал	1,397.5	9,165.9	7,768.4
Хангамжийн материал	168,698.5	179,931.8	11,233.3
Мал амьтад	19,247.7	17,167.7	-2,080.0
Дүн	189,343.7	206,265.4	16,921.6
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Ахлах сургууль	73,306.7	90,299.0	16,992.30
ЗДТГ	33,672.6	29,389.7	-4,282.90
ИТХ	887.5	87.5	-800.00
Соёлын төв	11,506.5	11,938.5	432.00
Цэцэрлэг	53,078.5	48,141.3	-4,937.20
ЭМТ	2,966.9	12,109.8	9,142.90
Бага сургууль	13,925.0	14,299.6	374.60
Дүн	189,343.7	206,265.4	16,921.70

Эх сурвалж: Өндөр-Улаан сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын 43.8 хувь буюу 90,299.0 мянган төгрөгийн бараа материал нь Ахлах сургуулийн, 14.2 хувь буюу 29,389.7 мянган төгрөгийн материал нь ЗДТГ-ийн , 23.3 хувь буюу 48,141.3 мянган төгрөгийн материал нь хүүхдийн цэцэрлэгийн, 6.9 хувь буюу 14,299.6 мянган төгрөгийн материал нь Бага сургуулийн, 5.8 хувь буюу 12,109.8 мянган төгрөгийн материал нь ЭМТөвөийн, 5.7 хувь буюу 11,938.5 мянган төгрөгийн материал нь Соёлын төвийн бараа материал байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 401,024.2 мянган төгрөгийн, хандив тусламжаар 13,413.5 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээр 53,006.8 мянган төгрөгийн материал авсан бөгөөд 412,543.1 мянган төгрөгийн материалыг зарцуулж, 37,979.6 мянган төгрөгийн материалыг данс хооронд шилжүүлж нийт 206,265.4 мянган төгрөгийн материалын үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Ахлах сургуулийн бараа материалын дэлгэрэнгүй тайланд 21 нэр төрлийн 9,544.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгаа ба үүнээс 5 нэр төрлийн 1,775.3 мянган төгрөгийн хөрөнгийг тайлант онд нэмж бүртгэсэнг бараа материал хөрөнгийг үнэн зөв бүртгэх албан шаардлага хүргүүлэн ажилласан байна.
- ЗДТГазрын шатахууны зарцуулалтыг ЗТХС-ын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан жишиг нормоор давтан тооцоолж шалгахад 606.1 мянган төгрөгийн шатахууныг илүү зарцуулсан, автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг баримталж тогтоогоогүй зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлсэн байна.
- Соёлын төв нь 585.4 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлсэн.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,312,817.1 мянга, эцсийн үлдэгдэл 6,226,923.4 мянган төгрөг болж, 85,893.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+),
			Бууралт (-)
Биет хөрөнгө	6,148,586.7	6,060,864.3	-87,722.4
Биет бус хөрөнгө	164,230.4	166,059.1	1,828.7
Дүн	6,312,817.1	6,226,923.4	-85,893.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Ахлах сургууль	2,582,066.3	2,524,070.4	-57,995.9
ЗДТГ	1,864,703.1	1,851,567.3	-13,135.8
ИТХ	17,987.6	22,035.7	4,048.1
Соёлын төв	472,113.4	464,262.8	-7,850.6
Хүүхдийн цэцэрлэг	643,275.9	644,794.2	1,518.3
ЭМТ	650,231.1	647,732.1	-2,499.0
Бага сургууль	82,439.7	72,460.9	-9,978.8
Дүн	6,312,817.1	6,226,923.4	-85,893.7

Эх сурвалж: Өндөр-Улаан сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 12,849.3 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хандиваар авсан 30,592.3 мянган төгрөгийн, шилжүүлэн авсан 104,493.6 мянган төгрөгийн, бусад байгууллагаас 213,779.2 мянган төгрөгийн нийт 361,714.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн бол 33,309.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан бол 4,200.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

2020 оны ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- Бага сургуулийн СТА-р 1,793.1 мянган төгрөгийн зөөврийн компьютерыг тавилга эд хогшилд бүртгэсэн зөрчил илэрснийг аудитын явцад залруулан ажилласан

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,978,197.4 мянга, эцсийн үлдэгдэл 7,059,836.9 мянган төгрөг болж, 81,639.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /МЯН.ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал	2,839,967.7	2,839,967.7	0.0
Хуримтлагдсан үр дүн	2,274,146.5	2,355,786.0	81,639.5
Өмнөх үеийн үр дүн	2,274,146.5	2,274,146.6	0.1
Тайлант үеийн үр дүн		81,639.4	81,639.4
Хөрөнгийн дахин үнэлгээний	1,864,083.2	1,864,083.2	0.0
Дүн	6,978,197.4	7,059,836.9	81,639.5

Эх сурвалж: Өндөр-Улаан сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн болох 81,639.5 мянган төгрөгөөр өсч тайлагнагдсан байна.

3.5.10 Орлогын данс

Өндөр-Улаан сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар 3,766,159.3 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг тайлагнасан нь өмнөх оноос 1,157,347.0 мянган төгрөгөөр буурсан байна. Үр дүнгийн тайлангийн нийт орлогыг задалбал:

1. Татварын орлого 251,032.7 мянган төгрөг,
2. Татварын бус орлого 426,277.3 мянган төгрөг байна. Үүнээс: төсөвт байгууллагын өөрийн орлого 9,686.7 мянган төгрөг, нийтлэг татварын бус орлого 1,275.1 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 415,285.4 мянган төгрөг, бусад орлого буюу нэр заагдаагүй бусад орлого 30.0 мянган төгрөг байна.
3. Тусламж санхүүжилтийн орлого 3,088,849.3 мянган төгрөг байна. Үүнээс: улсын төсвөөс 2,242,581.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 26,745.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 759,201.4 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 60,320.9 мянган төгрөг байна.

3.5.11 Зардлын данс

Өндөр-Улаан сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардал 3,999,377.1 мянган төгрөг, үйл ажиллагааны бус зардал 167,762.9 мянган төгрөг нийт 4,167,140.0 мянган төгрөгийн зардал тайлагнагдаж тайлант үеийн үр дүн өмнөх оноос 81,639.4 мянган болж буурсан нь үнэ төлбөргүй хандив тусламжаар хүлээн авсан хөрөнгөөс шалтгаалсан байна. Тайлант жилд 482,620.2 мянган төгрөгийн санхүүжилт хоорондын тооцоог устгах бичилтээр хийж тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

1. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдад сурах бичиг түрээсээр төлбөртэй ашиглуулах салбарын сайдын 2019 онд баталсан А/302 дугаар тушаалаар баталсан журмын дагуу 2019 онд БШУЯ-наас хүлээлгэн өгсөн дунд, ахлах ангийн 3,687.3 мянган төгрөгийн түрээсийн үнэтэй сурах бичгийн төлбөрийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлээгүй бэлнээр авч СБТТогтолцоо-Эргэлтийн сан 10090015403 тоот дансанд тушаасанд зөрчлийг арилгуулах зөвлөмж хүргүүлсэн
2. Ерөнхий боловсролын сургууль нь анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад 600.0 мянган төгрөгийг зарцуулсан, МУЗГ-ын 2019 оны 5-р тогтоолоор баталсан журмын 3.3-д заасаныг зөрчиж ажилтнуудад хавтгайруулан 2160.0 мянган төгрөгийн шагнал олгосон байна.
3. Сумын ИТХурал нь цалингийн зардлаас үр дүнгийн урамшуулал олгохдоо 11 сард томилогдсон даргад 90.7 мянган төгрөгийн урамшуулал тооцож олгосонд зөрчилд төлбөрийн акт тогтоосон
4. Хүүхдийн цэцэрлэгийн түлш халаалтын зардлаас түлшний нөөц бэлтгэсэн 1,000.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон
5. ЭМТөв нь тушаал шийдвэргүйгээр унаа хоолны хөнгөлөлт илүү тооцож олгосон 1,006.0 мянган төгрөгийн өрчилд төлбөрийн акт тогтоосон.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

✓ Орон нутгийн төсвийн орлогын талаар:

Орон нутгийн төсвийн орлогыг 94,518.0 мянган төгрөгөөр төсөвлөж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлснийг 10,473.0 мянган төгрөгөөр өсгөн 104,991.0 мянган төгрөгөөр анх баталсан байна. Орлого нэмэгдүүлэн баталсан гол шалтгаан нь ан амьтны нөөц ашигласны төлбөрийг 10,036.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Харин төсөв батлах тухай тодотгосон тогтоолоор шууд бус орлогыг 30,620.0 мянган төгрөгөөр нэмгдүүлсэн бол 3 нэр төрлийн орлогыг 11,060.0 мянган төгрөгөөр бууруулсан байна. Тайлант онд 16 нэр төрлийн 124,551.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Харин гүйцэтгэлээр 253,902.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 203.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 6. Төвлөрүүлэх орлого

/мян. төгрөг/

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого	4,100.0	5,389.5	1,289.5	131.5

2	Шууд бус орлого	33,220.0	63,403.9	30,183.9	190.9
3	Хадгаламжийн хүүгийн орлого	27,000.0	83,021.8	56,021.8	307.5
4	Үл хөдлөх хөрөнгө борлуулсаны орлого	150.0	2,662.1	2,512.1	1,774.7
5	Бууны татварын орлого	2,910.0	2,910.0	-	100.0
6	Улсын тэмдэгтийн хураамжийн орлого	2,780.0	3,245.3	465.3	116.7
7	Газрын төлбөр		42.5	42.5	
8	Газрын дуудлага худалдааны орлого	9,400.0	43,693.3	34,293.3	464.8
9	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	545.0	876.8	331.8	160.9
10	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	10,000.0	10,828.0	828.0	108.3
11	Байгалийн ургамал ашигласны төлбөр	58.0	58.0	-	100.0
12	Ойн нөөц ашигласны төлбөр	32,322.0	34,566.4	2,244.4	106.9
13	Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	116.0	335.2	219.2	289.0
14	Төсөвт байгууллагын өөрийн орлого	950.0	1,564.7	614.7	164.7
15	Хүү торгуулийн орлого	500.0	1,275.1	775.1	255.0
16	Нэр заагдаагүй бусад орлого	500.0	30.0	(470.0)	6.0
	Дүн	124,551.0	253,902.6	129,351.6	203.9

Орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давж биелсэн боловч нэр заагдаагүй бусад орлого 470.0 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулаагүй мөн иргэд зөрчил дутагдал үүсгээгүйтэй холбоотой байна.

Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын анхны болон тодотгосон төсөв батлах тухай тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг дараах байдлаар баталсан байна.

Хүснэгт 7. Төсвийн төлөвлөлт

№	Санхүүжүүлэх эх үүсвэр	Анх баталсан мөнгөн дүн	Тодотгон баталсан мөнгөн дүн	Зөрүү
1	Орон нутгийн ерөнхий орлого	104,041.0	123,601.0	19,560.0
2	Төсөвт байгууллагуудын үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого	232,400.0	232,400.0	0.0
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	354,750.2	329,954.2	-24,796.0
4	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	185,274.9	207,147.7	21,872.8
5	Тусгай зориулалтын шилжүүлэг	2,670,909.9	2,530,006.3	-140,903.6
6	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	7,000.0	28,450.3	21,450.3
7	Урьд оны ОНХС-ийн үлдэгдлээс санхүүжих	6,348.7	5,704.8	-643.9

Нийт дүн		3,560,724.7	3,457,264.3	-103,460.4
Байгууллагын нэр				
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	63,557.5	67,246.5	3,689.0
2	Засаг даргын тамгын газар	403,183.7	415,709.0	12,525.3
3	Орон нутгийн хөгжлийн сан	191,623.6	212,852.5	21,228.9
4	Сум хөгжүүлэх сан	230,000.0	230,000.0	0.0
5	Сургуулийн өмнөх боловсрол	556,659.4	502,472.7	-54,186.7
6	Ерөнхий боловсролын сургууль	1,309,995.7	1,226,210.4	-83,785.3
7	Бага сургууль	168,850.7	167,365.1	-1,485.6
8	Соёлын төв	102,419.8	102,419.8	0.0
9	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	534,434.3	532,988.3	-1,446.0
Нийт дүн		3,560,724.7	3,457,264.3	-103,460.4

Тайлант онд төсвийн орлогын эхний хагас жилийн гүйцэтгэлийг үндэслэн шууд бус орлогыг 30,620.0 мянган төгрөгөөр нэмж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг 395.0 мянган төгрөгөөр, ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг 645.0 мянган төгрөгөөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийг 10,020.0 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

Тодотголоор дараах байгууллагуудын зардлыг нэмж баталсан байна. Үүнд:

1. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын зардлыг 3,689.0 мянган төгрөгөөр,
2. ЗДТГазрын зардлыг 12,525.3 мянган төгрөгөөр,
3. ОНХСанг 21,228.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Харин Ковид-19 цар тахалтай холбогдуулан тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагын үйл ажиллагаа түр хаасантай холбоотойгоор тусгай зориулалтын шилжүүлгээс нийт 140,903.6 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Өндөр-Улаан сум нийт зардлын төлөвлөгөөг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 08 тоот тогтоолоор 3,560,724.7 мянган төгрөгөөр анх баталсан бөгөөд Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 05 тоот тогтоолоор төсвийн зохицуулалт хийж, ЗДТГ-т 12,525.3 мянган төгрөгөөр, ИТХ-д 3689.0 мянган төгрөгөөр, ОНХСанг 21,228.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн бол СӨБ-г 54,186.7 мянган төгрөгөөр, ЕБС-г 83,785.3 мянган төгрөгөөр, Бага сургуулийг 1,485.6 мянган төгрөгөөр, ЭМТөвийг 1,446.0 мянган төгрөгөөр хасах тодотгол хийж, нийт зардлын хэмжээг 3,457,264.3 мянган төгрөгөөр баталжээ.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 3,457,264.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,025,861.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 214,852.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 227,250.0 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлд зарцуулахаар батлагджээ.

Харин аймгийн ИТХ-ын “Аймгийн 2020 оны төсөвт зохицуулалт хийж тодотгон батлах тухай” 2020 оны 12 сарын 13-ны өдрийн 04 тоот тогтоолоор ЕБС, СӨБоловсролын байгууллагуудыг 5,350.0 мянган төгрөгөөр бууруулж сумын нийт зардлыг 3,462,614.3 мянган төгрөгөөр баталсан нь ковид-19 цар тахлын улмаас хэмнэгдэж байгаа сургуулийн

хүүхдийн үдийн хоол, цайны зардлын санхүүжилтээс Сангийн яам төсөвт зохицуулалт хийн буцаан татсантай холбоотой байна.

Нийт зардлын 2,251,756.8 мянган төгрөг буюу 65.1 хувийг улсын төсвөөс, 882,802.3 мянган төгрөг буюу 25.5 хувийг орон нутгийн төсвөөс, 61,500.0 мянган төгрөг буюу 1.8 хувийг ЭМД-аас, 266,555.2 мянган төгрөг буюу 7.7 хувийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,361,821.9 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь урсгал зардлаас 51,013.8 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 49,778.5 мянган төгрөг хэмнэгдэж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Тайлант жил ОНХСангийн хөрөнгөөр 7 төсөл, арга хэмжээнд нийт 163,073.9 мянган төгрөгийн санхүүжилт зарцуулагдсан байна. Үүнээс барилга байгууламжид 82,755.0 мянган төгрөг, их засварт 21,900.0 мянган төгрөг, тоног төхөөрөмжид 58,418.9 мянган төгрөг тус тус зарцуулагдсан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс 3,834.6 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 22,911.0 мянган төгрөг нийт 26,745.6 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна. Үүнээс Эрүүл мэндийн төв 2,277.6 мянган төгрөг, ЗДТГазар 20,633.4 мянган төгрөг, Ахлах сургууль 3,834.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 143 мэдээллээс 100 мэдээллийг хугацаанд нь, 43 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсанд аудитаас албан шаардлага хүргүүлээ.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар аудитаар нийт 40,875.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 16,644.2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 24,231.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүснэгт №8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/мянган төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт							
Албан шаардлага	1	16,644.2	1	16,644.2			100
Зөвлөмж	2	24,231.5	1	9,831.5	1	14,400.0	50
Нийт	3	40875.7	2	26,475.7	1	14,400.0	75

Хүснэгтээс харахад СХСангийн 14,400.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Өндөр-Улаан сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 7 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Өндөр-Улаан сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №9.Аудитын дүнгийн талаар:

Байгууллагын нэр	Байгууллагын тоо					Аудитын санал дүгнэлтийн төрөл	
	Аудитад хамрагдсан	Үүнээс				Бүгд	Үүнээс
		Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Итгэл үзүүлсэн	Аудит хийгдээгүй		
Ахлах сургууль	1	1				1	1
Бага сургууль	1		1				
Хүүхдийн цэцэрлэг	1	1				1	1
ЗДТГ	1	1				1	1
ИТХурал	1	1				1	1
Эрүүл мэндийн төв	1	1				1	1
Соёлын төв	1		1				
ОНХС	1		1				
СХС	1		1				
НИЙТ ДҮН	9	5	4	-	-	5	5

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн 5 төсөвт байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, бага сургууль, соёлын төв, 2 төсөл санг түүвэрт хамруулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 345,022.7 мянган төгрөгийн төлбөр зөрчил илэрч 1,303.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 340,949.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж, 2,408.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 361.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт хүргүүлэн ажилласан байна.

Хүснэгт №10. Төсвийн шууд захирагчдын төлбөр зөрчлийн нэгтгэл /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчил		Үүнээс				Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
			Залруулсан алдаа		Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ахлах сургууль	4	3,687.3			4	3,687.3			2		2	3,687.3

Хүүхдийн цэцэрлэг	3	57,210.1			3	57,210.1	1	1,000.0	1	56,210.1	1	
ЗДТГ	4	3,766.1	1	400.0	3	3,366.1			3	3,366.1		
ИТХурал	2	90.7			2	90.7		90.7	1		1	
Эрүүл мэндийн төв	3	62,319.3			3	62,319.3	1	1,006.0	1	61,313.3	1	
Соёлын төв	3	585.4			3	585.4			1	585.4	2	
НИЙТ ДҮН	19	127,658.9	1	400.0	18	127,258.9	2	2,096.7	9	121,474.9	7	3,687.3

Алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 3,745.4 мянган төгрөгийн, арвилан хэмнэлттэй холбоотой 2,096.7 мянган төгрөгийн, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 121,816.8 мянган төгрөгийн алдаа зөрчил тус тус илэрсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар:

Өндөр-Улаан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 44,331.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, шилэн дансны мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан 43 мэдэлэлд 1 албан шаардлага, 44,331.7 мянган төгрөгийн зөрчилд менежмент захидлаар зөвлөмж хүргүүлээ.

Хүснэгт №11 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төлбөр зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/




Байгууллагын нэр	Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт									
			Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Сум хөгжүүлэх сан	1	44,331.7					1	44,331.7				
Нэгдсэн тайлан	1				1							
НИЙТ ДҮН	2	44,331.7			1		1					

1. Шилэн дансны мэдээллийг тулган шалгахад 100 мэдээллийг хугацаанд нь 43 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсанд аудитаас албан шаардлага хүргүүлээ.
2. Авлагын бүртгэлийг тулган үзэхэд сум хөгжүүлэх сангийн хэвийн зээлийн хэмжээ 366,106.2 мянган төгрөг, хугацаа хэтэрсэн зээл 41,791.4 мянган төгрөг, чанаргүй зээл 2,540.3 мянган төгрөг байгаа зөрчилд аудитаас зөвлөмж хүргүүлээ.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитад шилэн дансны мэдээлэл, сум хөгжүүлэх сангийн талаар шалгах зүйтэй гэж үзлээ.

АУДИТЫН ТАЙЛАН

Бэлтгэсэн:	Аудитор		Ж.Мөнгөншагай
Анхан шатанд хянасан:	Аудитын менежер		Т.Байгалмаа
Хоёр дахь шатанд хянасан:	Тэргүүлэх аудитор		Д.Уламбаяр

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал:

- 1.1. **Илрүүлэлт:** Авлагын бүртгэлийг тулган үзэхэд сум хөгжүүлэх сангийн хэвийн зээлийн хэмжээ 366,106.2 мянган төгрөг, хугацаа хэтэрсэн зээл 41,791.4 мянган төгрөг, чанаргүй зээл 2,540.3 мянган төгрөг байгаа зөрчилд аудитаас зөвлөмж хүргүүллээ.
- 1.2. **Эрсдэл:** Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, эх үүсвэр боломжит хэмжээнд төвлөрөхгүй байх, зарцуулалт үр дүнгүй болох улмаар найдваргүй авлага үүсэх эрсдэлийг бий болгож болзошгүй байна.
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн биелүүлэхэд цаг алдалгүй тодорхой арга хэмжээ авч, Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмыг мөрдөж ажиллах
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.03.25	Аудитын нэр:	Өндөр-Улаан сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: АРА-2021/4/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Өндөр-Улаан сумын ТЕЗ		мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мян төгрөг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Өгийнуур сумын шилэн дансны мэдээллийг тулган шалгахад 100 мэдээллийг хугацаанд нь 43 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.		Албан шаардлага	Засаг дарга, Санхүү албаны дарга	Ю.Баасанжаргал Г.Пүрэвжаргал
3	Авлагын бүртгэлийг тулган үзэхэд сум хөгжүүлэх сангийн хэвийн зээлийн хэмжээ 366,106.2 мянган төгрөг, хугацаа хэтэрсэн зээл 41,791.4 мянган төгрөг, чанаргүй зээл 2,540.3 мянган төгрөг байна.	44,331.7	Зөвлөмж өгөх		
	ДҮН	44,331.7			